

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Yүсгэн байгуулагчийн сургаал

Аз хийморь, гай барцад нь алганы хоёр тал юм

Шинэ он гарахад байгууллагууд хүний нөөцийн шилжилт, эсвэл суудал солих зэргээр өөрчлөлт их хийдэг. Энэ өөрчлөлтөөр дамжуулж өөрийгөө шинэ зүйлд сорих хүн байхад, нөгөөтэйгүүр “компани маань миний хичээл зүтгэлийг үнэлэхгүй байна” гээд санаагаар унах хүн ч байдаг.

Хүмүүс бид аливаа зүйлийг “дургүй”, “дуртай” гэж хоёр хуваах хандлагатай байдаг бөгөөд сэтгэлд нийцэхгүй зүйл байвал өөрийгөө азгүйд тооцож, сэтгэлд нийцэх зүйл байвал азтай байна гэж боддог. Гэвч аз хийморь, гай барцад нь алганы хоёр тал шиг тийм л ойр зүйл юм.

Бороо орсон бол дараагийн өдөр нь тэнгэр цэлмэдэг. Цэлмэг өдрүүд үргэлжилбэл, дараа нь

бороотой өдөр ирэх нь гарцаагүй. Үргэлж л хавар, зун шиг нарлаг, налайсан өдрүүд үргэлжлэх юм шиг санавал өвлийн хүйтнийг давахад бэрх болно. Харин өвлийн өдрүүдэд хүчээ сойж, биеэ бэлдвэл тэр хүчээ гарган, эр бяраа гайхуулах хавар цаг ирэх нь гарцаагүй.

Таатай нөхцөл байдал боломж юм бол таагүй өөрчлөлт ч шинэ боломж завшааны үүд хаалга юм. Аль зүг рүү нь залах вэ гэдэг асуудлыг та хэрхэн хүлээж авахаас шалтгаална. “Миний одоогийн байгаа газар бол намайг дээд зэргээр хөгжүүлэх, бэлтгэл хийх газар” гэж сэтгэлдээ хатуу шийдэх юм бол тэр дороо л үр дүн нь харагдах болно.

Yүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.40-41

Living the Lotus Vol. 162 (2019,03)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Yүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдрал)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Өөртөө болон бусдад аз жаргалыг хүсэх сэтгэл

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Бурханы хүүхэд” учраас

Бүх хүн гэр бүлийнхнийгээ аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Түүний зэрэгцээ бидэнд бусдын аз жаргалыг хүсэх сэтгэл ч байдаг.

Хэмжээлшгүй Утгасын сударт *“Та бүгд эдүгээ үнэн магад бурханы хөвгүүд болой. Агуу их энэрэл, их нигүүлслээр сайтар зовлонгоос тонилгон зэтгэрээс аврагч болой”* (3-р бүлэг Арван эрдэм буяныг үгүүлэх) (орч.Болдбаатар.Т УБ.,(2012), “Адмон принт” хэвлэл, 34 тал) гэсэн хэсэг байдаг. Энэ нь “Агуу их нигүүлсэнгүй сэтгэлээр хүмүүсийг зовлонгоос нь салгаж, гай барцадаас аварч чадна” гэсэн утгатай. Та бүхэн өөрт ийм үүрэг байгаа гэдгээ мэдэж байна уу?

Судрын дээр дурьдсан хэсгийн өмнө “та бүхэн ямарч эргэлзээгүй бурханы хүүхэд болой” гэсэн үг байна.

Өөрөөр хэлбэл “бурханы хүүхэд учраас бусад хүмүүсийг зовлонгоос ангижруулж, гай барцадаас аварч чадна” гэсэн үг юм.

Ингээд бодохоор бидний хувьд “бурханы хүүхэд” гэсэн ухамсар бий юу үгүй юу гэдэг чухал асуудал болох юм шиг санагдаж магадгүй. Гэвч бодот байдал дээр бурханы хүүхэд гэдгээ ухамсарладаг хүн тийм олон байхгүй болов уу.

Тэгвэл явал Бурханы хүүхэд гэдгээ ойлгох вэ? “Бидний амь нас угтаа хувьсан өөрчлөгдөх бөгөөд харилцан холбоотой байдаг” гэдгийг ойлгох үед “бурханы хүүхэд” юм байна гэж бодох болно. Гурван зүй тогтлын сургаал (“Бүх юмс мөнх бус”, “Юу ч ганцаар оршин тогтнодоггүй”, “Нирваан нь туйлын амгалан”)-аас суралцаж, эсвэл бусдаас сонсоод “үнэхээр тийм шүү” гэж чин сэтгэлээсээ ойлгон хүлээж авч чадаж байгаа нь “бурханы хүүхэд” учраас юм.

“Анх удаа боди сэтгэлийг үүсгэх үе нь гэгээрлийн үүд нээгдэх үе юм” хэмээх Аватамсака судрын нэг мөрт байдаг. “Бурханы сургаалын үүдний өмнө зогсох үед, тухайн хүн аль хэдийн бурханы гэгээрлийн нэг хэсгээс мэдэрсэн” гэсэн утгатай. Тиймээс өчүүхэн ч гэсэн “юмс үзэгдэл байнга өөрчлөгдөж байдаг”, “бүх зүйл бурханлаг чанарын илэрхийлэл бөгөөд хорвоогийн бүхий л зүйлс агуу зохилдлоготой байдаг” гэж анзаарах юм бол, тэр нь гарцаагүй “бурханы хүүхэд”-н ухамсар мөн бөгөөд тэр хүн бусдын аз жаргалын төлөө залбирдаг, бусдад аз жаргалыг түгээдэг бодисадва мөн гэж хэлж болно.





Амьд судар

РКК-д “элсэж ороод шууд сургаал түгээгч болно” гэсэн үг байдаг. Энгийнээр бодоод үзэхэд дөнгөж элсэж орсон шинэхэн гишүүн бусдад бурханы сургаалыг түгээж яаж чадах билээ гэж бодох байх. Гэвч судар дотор “өөрөө хараахан төөрөгдөлөөс ангижирч чадаагүй байгаа ч бурханы сургаалыг сонссон хүн зовж шаналж байгаа хүнд тусалж чадна” гэж маш тодорхой дурьдсан байдаг.

Жишээлбэл найздаа маш их уур нь хүрч байгаа хүн байлаа гэж бодъё. Тэр хүн бурханы сургаалыг сонсоод “миний уур бухимдлын шалтгаан нь найзыгаа өөрийнхөө бодсоноор байлгах гэсэн атгаг сэтгэлтэй минь холбоотой байжээ” гэж өөртөө дүгнэлт хийжээ. Эцэст нь тэр хүн найзтайгаа эвлэрч чадсан ба тэр туршлагаа хэн нэгнийг удаан хугацааны туршид үзэн ядаж байгаа хүнд ярьснаар, нөгөө хүнд “би ч гэсэн асуудлыг ийм талаас нь олж хармаар байна, ингэж хүлээж авдаг болмоор байна”, “аз жаргалтай болмоор байна” гэсэн бодол төрүүлж болно.

Яагаад гэхээр та өөрөө хараахан дутуу дулимаг байлаа ч гэсэн бурханы сургаал нь үнэн зөв учраас юм. Мөн хүн бүр бусадтай эвтэй байхыг хүсдэг учраас юм. Тийм учраас л бурханы сургаалыг сонсоод анзаарсан зүйл, сэтгэлийг тань хөдөлгөсөн зүйлийн тухай байгаагаар нь ярих төдийд л “би ч гэсэн энэ хүн шиг гэгээлэг, баригдмал бус ийм чөлөөтэй сэтгэлээр амьдармаар байна” гэсэн хүсэл, “зовж шаналж байгаа хүнд тусалж, аз жаргалтай болох баяр хөөрийг хамтдаа мэдэрмээр байна” гэсэн бусдын сайн сайхны төлөө бодох сэтгэлийг төрүүлж болно.

Сударт “энэхүү сургаал нь хүмүүс бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэх газарт оршино” гэж гардаг. Тиймээс эрч хүчээр дүүрэн амьдрах өөрийн дүр төрхөөрөө дамжуулж, зовж шаналж байгаа хүмүүсийн зүрх сэтгэлд сургаалын гэрлийг түгээж, амар амгалан амьдрал руу хөтлөх хүмүүс болцгооё.

Ийм ч утгаараа бид бүхэн хэзээ ч хаана ч “өөдрөг, энэрэнгүй, дулаан” хүн болохыг мартажгүй байх хэрэгтэй. Судрын хэсгээс сайн тайлбарлаж чадахгүй байлаа ч, бусдын төлөө бодож, үйлддэг хүн нь өөртөө болон бусдад аз жаргалыг түгээдэг “амьд судар” болж чадна.

«Косей» сэтгүүл 3-р сарын сургаалаас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Эмийн өвсөөр үлгэрлэхийг үгүүлэхүй 5-р бүлэг



“Сүслэн авахуйг үгүүлэхүй 4-р бүлэг”-т Маха-Каашяпа өөрийн турлагаа ярьдаг. Түүнийг сонссон Шагжамүни будда энэ бүлэгт “Сайн байна, Каашяпа. Чи Түүнчлэн ирсний жинхэнэ буяны талаар маш зөв ярилаа.” хэмээн магтаад, бурханы сургаал ба түүнийг хүлээж авах хамаг амьтан хэрхэн холбогддог болохыг

“Гурван өвс ба хоёр модны жишээ” хэмээх сургаалаар дамжуулан илүү ойлгомжтой тайлбарлаж өгдөг. Тэр сургаал нь дараах агуулгатай.

Гурван өвс ба хоёр модны жишээ

“Каашяпа, чиний хэлсэн туйлын зөв. Бурханы буян хязгааргүй. Түүнчлэн ирсэн нь жинхэнэ үнэнийг төгс мэддэг ба түүнийгээ чөлөөтэй айлдан бүх хүмүүст эрх тэгш амьдралыг өгч, эцэст нь төгс төгөлдөр бурханы билиг оюунд хүргэдэг юм. Жишээ татан хэлбэл, газар дээр олон төрлийн өвс, мод сагсайн ургасан байдаг. Тэдгээр өвс, модны хэмжээ нь том, дунд зэрэг, жижиг байх ба шинж чанар, хэлбэр төрх нь ч гэсэн харилцан адилгүй. Харин тэд адилхан л ус чийгийг хүсдэг.

Гэтэл тэнгэр дүүрэн их үүл бүрхэж бороо оров. Бороо бүх газарт цутган оржээ. Бүхий л өвс, моддыг ижилхэн хангалттай чийглэж өгөв. Жижигхэн өвс, дунд зэргийн өвс, өндөр өвс ч гэсэн, жижиг мод, том мод ч гэсэн бүгд тэр чийгийг аван сэргэж, гялалзтал өсөж ургана. Бороо ийнхүү нэгэн жигд цутган ордог боловч өвс, модны өсөж ургах явц, хэлбэр төрх, дэлбээлэх цэцэг, боловсрох үр жимс нь төрлөөсөө шалтгаалаад өөр өөр байдаг билээ.

Каашяпа, Түүнчлэн ирсэн нь тэнгэр бүрхэх их үүлтэй адилхан. Түүнчлэн ирсэний сургаал нь бүх газарт цутган орох бороотой адилхан. Хамаг амьтан бол том, дунд зэрэг, жижиг олон янзын өвс, модтой адилхан билээ.

Түүнчлэн ирсэний сургаал бол энэхүү сансар огторгуйн жинхэнэ үнэн юм. Жинхэнэ

үнэн гэдэг нь угтаа ганцхан зүйл буюу “Хамаг юмсын жинхэнэ дүр төрх”-ийг хэлдэг. Тиймээс Түүнчлэн ирсэний айлдах сургаал нь ч гэсэн цутган орох борооны адил нэг л ижил зүйл байдаг. Гэвч хүмүүсийн төрөлхийн зан чанар өөр өөр байдаг. Амьдрал, эрүүл мэнд, өссөн орчин бүгд ондоо. Тийм учраас бүх хүн адилхан бурханлаг чанартай мөртлөө жинхэнэ үнэний сургаалын хурыг хүлээж авах өнцөг нь өөр өөр байдаг байна.”

Гэхдээ хэдийгээр хүлээж авах өнцөг нь өөр ч гэсэн хүн болгон жинхэнэ үнэний хурыг хүлээн авч, хувийн онцлогийнхоо дагуу өөрийгөө хөгжүүлж, өөрийн гэсэн цэцгийг дэлбээлүүлж, өөрийн гэсэн үр жимсийг ургуулдаг гэдгээрээ адилхан юм. Ургамал өөрийнхөө том, дунд зэрэг, жижиг хэмжээтэйг огт мэдэхгүй. Зүгээр л өөрт заяасан шинж чанарынхаа дагуу улам бүр өсөж ургадаг.

Хүн ч гэсэн гэсэн бурханы нүдээр харахад өвс, ургамалтай төстэй. Одоо ямар түвшинд байгаагаа, сансар огторгуйд хэр хэмжээний үнэ цэнэтэй болохоо үнэн зөвөөр нь мэддэг хүн байхгүй. Үүнийг зөвхөн Бурхан л мэднэ. Бурхан нь бүх хүмүүсийн одоогийн нөхцөл байдал, сэтгэлзүйн түвшний ялгааг үнэн зөв мэдэхийн





Угийн эрх тэгш тал ба өнгөц харагдах ялгаатай тал

Дээрх жишээ нь ерөнхийдөө “бурханы сургаалын өнгөц харагдах хүмүүсийг аврах ялгаатай тал ба угийн эрх тэгш тал”-ын талаар айлдсан байдаг. Гэхдээ өнөөгийн бид бүхэн энэ жишээнээс “хүмүүсийн угийн эрх тэгш төрх ба өнгөц харагдах ялгаатай төрхийг хоёуланг нь сайтар танин мэдэх нь жинхэнэ билиг оюун болно” гэдгийг ухаан ойлгох чухал.

Аливаа зүйлийн угийн эрх тэгш талыг нь л хараад суугаад байвал бодит ертөнцөөс тасарсан хувраг мэт болж, бодит амьдралтай нийцэхгүй. Тэглээ гээд эсрэгээр өнгөц харагдах ялгаатай талыг нь л хараад байвал онгиороо сагсуу эсвэл сул дорой байдлаас үүсэх бэрхшээл (онгиорох, дорд үзэх, атаархах, өс санах, эсэргүүцэх гэх мэт) болон шуналаас үүдэх хэрүүл тэмцэл, зовлон байнга бий болж, хүний нийгэм сайхан болохгүй.

Хүн бүр өөр өөр дүр төрхтэй ч гэсэн угтаа яг тэр хэвээрээ Бурхантай нэгэн бүхэл гэдгийг сайтар ухаарснаар жинхэнэ утгаараа өөрөөрөө амьдарч, бусад хүмүүсийг ч гэсэн өөрөөр нь амьдруулах зөв амьдралыг туулж чадах юм. Орчин үед энэ бүлгийг ингэж ойлгож болно.

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Эш үзүүлснийг үгүүлэхүй 6-р бүлэг



“Сүслэн авахуйг үгүүлэх 4-р бүлэг”-т Маха-Каашяпа, Маха-Маудгалаяана, Субуди, Маха-Катяяана нар бурханы сургаалын жинхэнэ утгыг ойлгосноо өөрийн турлага дээр тулгуурлан айлтгадаг. Шагжамүни будда тэднийг магтаж энэ бүлэгт эш үзүүлж байгаагаар айлддаг. Эш үзүүлэх гэдэг нь “Уран арга 2-р бүлэг”-т гарсан шиг “Чи заавал бурханы гэгээрлийг олж, бурханы түвшинд хүрч чадах болой” хэмээн батлахыг хэлнэ.

үйл хийсний дараа ...” гэсэн нөхцөл байдаг. Өөрөөр хэлбэл бурханы гэгээрлийг олох их сургуульд тэнцлээ гэсэн үг болохоос биш төгсөлтийн диплом биш. Үргэлжлүүлээд заавал суралцах шаардлагатай гэсэн үг юм. “Үлгэрлэл бүлэг”-т тойруулан хэлсэн “бусдын хүч” ба “өөрийн хүч” гэдэг зүйл энэ бүлэгт дахин өөр хэлбэрээр гарч ирж байгааг анхаарууштай.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 73-74

Эш үзүүлэхэд нөхцөл бий

Гэхдээ ийнхүү батлахад заавал нөхцөл дагалдаж байдаг. Тэр нь “ийм ийм бурханы

Аз жаргалыг түгээдэг хүмүүс болцгооё

РКК байгууллага үүсгэн байгуулагдсаны ой тохиох 3 сар гарлаа. 100 жилийн ойг угтах эхлэл болсон 81 дэх жил гэж хэлж болно.


Нивано ерөнхийлөгчөөс гишүүд бид “өөрийгөө ахиулан хөгжүүлцгээ” гэсэн жилийн турш хэрэгжүүлэх даалгавар авсан билээ. Шинэ жилийн эхний айлдвараараа ерөнхийлөгч Зэн урсгалын их багш Доогэний хэлсэн “би чи гэж ялгах зүйлгүй” гэсэн үгийг иш татан тайлбарласан. Үүнийг сонсоод “бид бүгд нэгэн бүхэл” гэсэн ойлголтыг дахин ухаарсан.

Энэ сарын сургаал дээр Хязгааргүй Утгасын судар “Арван буян” 10-р бүлгээс иш татан “бурханы хүүхэд” гэсэн ойлголтыг тодотгож, бусдын сайн сайхны төлөө бодож, үйлдэл хийдэг, бусдад аз жаргал түгээдэг хүмүүс болцгооё гэж уриалсан байна. “Аль болох олон хүнд ЦЈС-г дурьддаг хүний амьдралын мөн чанарыг таниулж, жинхэнэ аз жаргалыг мэдрүүлмээр байна” хэмээх үүсгэн байгуулагчийн РКК-г байгуулсан хүсэл зорилгыг өөрийн хүсэл зорилго болгон энэ сар ч гэсэн сургаал түгээлтийн үйлсэд зүтгэх болно.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
 Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
 Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
 Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna**Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax: 39-06-48913949 e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**